



СЭЛЭНГЭ АЙМАГ
АЛТАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 17 өдөр

Дугаар А/107

Алтанбулаг

Бүх нийтийн хог цэвэрлэгээг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.6 "л", Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.1, 9.4.5, 9.4.12, Засгийн газрын "Шинэ Коронавирусын эрсдлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 2020 оны 30 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Бүх нийтийн хог цэвэрлэгээний өдөр"-ийг 2021 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн Пүрэв гарагийн 14:00 цагаас аж ахуйн нэгж байгууллагууд ойр орчим болон хариуцсан нутаг дэвсгэрээ, айл өрхүүд хашаа болон гудамж талбайгаа, 2021 оны 05 дугаар сарын 21 –ний өдрийн Баасан гарагт 12:00 цагаас Долоон даваа, Борын жалга, Хуурай нуур, Гялаан нуур, Гүн нуур, Хонд хүртэл замын орчмын хогийг цэвэрлэх ажлыг зохион байгуулсугай.

2. Багийн нутаг дэвсгэртээ байгаа хог хаягдлыг цэвэрлэх, зайлуулах ажилд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг татан оролцуулахыг багийн Засаг дарга (Б.Баттулга, Г.Жамбалдорж) нарт даалгасугай.

3. Багийн Засаг даргатай хамтран тус тусын хариуцсан нутаг дэвсгэрт ажиллахыг Байгаль хамгаалагч (З.Амарсайхан, Г.Март) нарт үүрэг болгосугай.

4. Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтэнд хяналт тавьж зөрчил гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгуулагад хуулийн хариуцлага хүлээлгэн зөрчлийг арилгуулахыг Байгаль орчны хяналтын улсын байцаагч (С.Мөнхзул)-д, Бүх нийтийн хог цэвэрлэгээний тайланг холбогдох газарт хүргүүлэхийг Байгаль хамгаалагч (Г.Март)-д үүрэг болгосугай.

5. Аж ахуйн нэгж, байгууллага өөрийн эзэмшлийн газрынхаа хог хаягдлыг цэвэрлэх болон зайлуулах олон нийтийг хамарсан ажилд идэвхтэй оролцохыг аж ахуйн нэгж, байгууллагын дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

6. Айл өрхүүдийг хашаа, гудамж болон ойр орчмынхоо хогийг байнга цэвэрлэж, хоггүй цэвэр орчин бүрдүүлж амьдрахыг нийт иргэдэд үүрэг болгосугай.

7. Бүх нийтийн хог цэвэрлэгээгээр гарсан хогийг сумын нэгдсэн хогийн цэг рүү тухай бүрт нь тээвэрлэж хаяхыг сумын аж ахуйн нэгж, байгууллагын дарга, эрхлэгч нар, Айл өрхүүд өөрсдийн хашаа болон гудамжнаас гарсан хог хаягдлыг өөрсдөө тээвэрлэн хаяхыг үүрэг болгосугай.

8. Бүх нийтийн хог цэвэрлэгээгээр гарсан хил орчим, төв зам дагуух хогийг сумын нэгдсэн хогийн цэг рүү тухай бүрт нь тээвэрлэж хаяхыг сумын гэрээт жижүүр (У.Володяа, Л.Болдсайхан)- нарт үүрэг болгосугай.

9. Бүх нийтийн хог цэвэрлэгээний үед цуглуулсан хогийг хогийн цэгт тээвэрлэхэд шаардагдах шатахуунаар хангаж ажиллахыг санхүү албаны дарга (Р.Үнэнбат)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Н.ОТГОНЦОГТ

Алтанбулаг сумын Засаг даргын 2021 оны 05 дүгээр сарын 17-ний өдрийн А/47 тоот захирамжийн хавсралт



АЛБАН БАЙГУУЛЛАГА, АЖ АХУЙН НӨГЖ, АЙЛ
ӨРХҮҮДИЙН БҮХ НИЙТИЙН ХОГ ЦЭВЭРЛЭГЭЭ ХИЙХ
АЖЛЫН ХУВААРЬ

№	Байгууллагын нэрс	Цэвэрлэгээ хийх газар	хугацаа	Хариуцах эзэн
1	ЗДТГазар	Байгууллагын орчин, Ахмадын толгой, Спорт талбай	2021.05.20	ЗДТГ-ын дарга Ү.Янжиндулам
2	ЕБС	Байгууллагын орчин, Станцаас-Сэлэмт хөшөө	2021.05.20	Захирал Б.Эрдэнэ-Очир
3	ЭМТ	Байгууллагын орчин, Мал эмнэлгийн байр	2021.05.20	Эрхлэгч У.Энхбямба
4	Найрамдал, Дамбо	Байгууллагын орчин, Солдат толгой	2021.05.20	Эрхлэгч Д.Болормаа, Ж.Мөнхтуяа
5	Соёлын төв	Байгууллагын орчин, Дайчдын хөшөө, Шар баар	2021.05.20	Эрхлэгч Б.Ариунзаяа
6	Аймгийн Нэгдсэн музей	Байгууллагын орчин, Ногоон байгууламж	2021.05.20	АНМ-н дарга И.Чулуунболд
7	3-р цэцэрлэг	Байгууллагын орчин, Бага сургууль	2021.05.20	Эрхлэгч Д.Лхагважав
8	ААН-үүд	Байгууллагын орчин,	2021.05.20	1,2-р багийн Засаг дарга Б.Баттулга
9	Айл өрхүүд	Хашаа болон гудамжаа	2021.05.20	1,2-р багийн Засаг дарга Б.Баттулга
10	Их цэвэрлэгээ	Долоон даваа, Гүн нуур, Хуурай нуур, Хонд, Борын жалга, Гялаан нуур	2021.05.21	Байгаль орчин, 3-р багийн Засаг дарга Г.Жамбалдорж